



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/02

Мандалговь

Г Гамшгаас хамгаалах сурталчилгааны
албаны штаб байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, аймгийн Засаг даргын 2014 оны А/117 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Гамшгаас хамгаалах сурталчилгааны албаны штабыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Штабын дарга: Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд, хүн ам зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан:

(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал ашигт малтмал, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Төлөвлөлт, бэлэн байдал, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтан:

(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Олон нийттэй харилцах ажилтан)

Холбоо зарлан мэдээлэл хариуцсан ажилтан:

(Төрийн сангийн хэлтсийн Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн)

Ар тал, хангалт хариуцсан ажилтан:

(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн)

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан:

(аймгийн Засаг даргын туслах)

Хоёр: Штабын гишүүдийг ажил үүргийн хуваарь, төлөвлөгөөний дагуу гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх дадлага чадвартай болгож бэлэн байдлыг хангаж ажиллахыг албаны штабын дарга (Р.Лхагвадорж)-д үүрэг болгосугай.

Гурав: Энэхүү тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/09 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

488060004